



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

᠒᠐᠒᠘ оны ᠕ сарын 31 өдөр

Дугаар ᠕/᠒᠑᠑

Улаанбаатар хот

Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1544 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Техникийн комиссын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдахаар шийдвэрлэгдсэн нийт 42,737,991.58 (дөчин хоёр сая долоон зуун гучин долоон мянга есөн зуун ерэн нэгэн төгрөг тавин найман мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий үлдэх өртөггүй 2 тээврийн хэрэгслийг данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба (Г.Мөнхбаатар)-нд зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлтийг хийж, тээврийн хэрэгслийн гэрчилгээ улсын дугаарыг хураан авч авто тээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс хасуулахыг Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба (Г.Мөнхбаатар)-нд үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул), тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т тус тус даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

В.Оюумаа В.ОЮУМАА

1150502240

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
даргын 2024 оны 12 дугаар сарын 21 -ны
өдрийн 1799 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах тээврийн хэрэгслийн жагсаалт

№	Автомашины марк	Улсын дугаар	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
1	Ниссан Патфиндер	49-59 УНР	3,400,000.00	3,400,000.00	-
2	Хьюндай санта фи	02-31 УБУ	39,337,991.58	39,337,991.58	-
Нийт дүн			42,737,991.58	42,737,991.58	